



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 532,000,000.00 (таван зуун гучин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 110,493,750.00 (нэг зуун арван сая дөрвөн зуун ерэн гурван мянган долоон зуун тавин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 3 (гурав) ширхэг автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Цагдаагийн ерөнхий газрын Авто баазын дарга, цагдаагийн хурандаа Ж.Булгантамир,"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Засгийн газрын авто бааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000180



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 05 өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ.
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1.Цагдаагийн ерөнхий газрын Авто баазад							
1	Тоёото Ландкрузейр-200 2003 УБИ арал JTMHX05J804167702	2018	ш	1	225,000,000.00	46,791,250.00	178,208,750.00
	Дүн			1	225,000,000.00	46,791,250.00	178,208,750.00
2."Засгийн газрын автобааз" УТҮГ-т							
1	Тоёото Ландкрузейр-200 1079 ОРА JTMHU01J5J4166877	2018	ш	1	153,500,000.00	31,851,250.00	121,648,750.00
2	Тоёото Ландкрузейр-200 1109 ОРА JTMHU01J6J5142954	2018	ш	1	153,500,000.00	31,851,250.00	121,648,750.00
	Дүн			2	307,000,000.00	63,702,500.00	243,297,500.00
				3	532,000,000.00	110,493,750.00	421,506,250.00
	Нийт дүн				(таван зуун гучин хоёр сая)	(нэг зуун арван сая дөрвөн зуун ерэн гурван мянган долоон зуун тавин)	(дөрвөн зуун хорин нэгэн сая таван зуун зургаан мянга хоёр зуун тавин)